

□
МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 6 сарын 30 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5, 47.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- 2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Энэ тушаалыг захиалагч байгууллагын 2022 оны төсвийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороо байгуулахтай холбоотойгоор 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.
- 4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/, Хууль, эрх зүйн газар /З.Энхболд/- т тус тус үүрэг болгосугай.

Б.ЖАВХЛАН